

**ДАРХАН-УУЛ АЙМАГ
“ИННОВА ЛОЖИСТИК” ХХК**

**2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

1. КОМПАНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
5. ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
6. НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН БИЕЛЭЛТ
9. БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД
ТАЙЛАГНАХ
10. БОМТ-ИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮГНЭЛТ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН НЭР

“Шийрийн хөндийн адаг-4 шохойн чулууны уурхай”

1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Шийрийн хөндийн шохойн чулуун уурхайг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглахад төслийн зорилготой оршино.

1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НЭР


“ИННОВАЛОЖИСТИК” ХХК

1.4 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Дархан уул аймгийн Хонгор сумын Шийрийн хөндийд 25 га талбай бүхий газар, Хонгор сумаас хойш 20 орчим км зайд байрладаг.

Зураг 1.

ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИ ЗУРАГ



а) Үйлдвэрийн танилцуулга

- “Инноваложистик” ХХК нь 2014 оны 05-р сард Шохойн чулуу баяжуулах үйлдвэрт шохой шатаах үндсэн чиглэлтэйгээр ашиглалтанд орсон .
- Жил бүр татвар төлдөг, татвар төлөгч байгууллага юм.
- Одоогийн байдлаар нийт 15 ажилтан албан хаагчидтай, ажиллах хүчний 80 гаруй хувь нь 25-40 насны иргэд байдаг.
- Дархан-Уул аймгийн Дархан сумын Шийрийн хөндийт 25 га газрыг АМХЭГазрын ГУУКАлбанаас олгосон 5655А дугаартай ашигт малтмал ашиглах лицензийн гэрчилгээнд тусгагдсан талбайд үйл ажиллагааг явуулж байна.

б) Төслийн хүчин чадал

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэсвгэр дэх Шийрийн хөндийн адагт орших шохойн чулууны 4-р ордод 1986-1993 онуудад олборлолт явуулж эхэлсэн. Нарийвчилсан хайгуулын ажлыг ЗХУ-ийн геологийн хайгуулын анги хийж 1962онд тус 4-р ордын нөөцийг С2 - 508.3мян.тн хэмжээтэйгээр тогтоосон байна. Ашиглалтын үед нийт геологийн нөөцөөс 280.2мян.тн-ийг ашиглаж. 34.1мян.тн-ийг ул, тааз, чулуулга үеийн бохирдолтоос овоолгод 337.1мян.тн-ийг үйлдвэрт ашиглах агуулга хангахгүй учир овоолгод хаясан байна. Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг Шийрийн хөндийн адаг дахь 4-р ордын ухсан карьерийн хэсгийг үргэлжлүүлэн ашиглах явцад ордын нөөцийг нэмэгдүүлэх. олборлолтоос гарах шохойн чулууг хэрэгцээт газарт нийлүүлэхээр төлөвлөсөн байна. 2003 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 1023т/м өрөмдлөг явуулж 6400 м3 уулын цул тэслэж 4925тн хадан хөрс хуулан. Үүнээс 10.000тн шохойн чулуу олборлохоор тусгажээ.

1. Инженерийн байгууламж:

Тээвэрлэлт :

- Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу жилд хамгийн ихдээ 117,4 мян.м3 хөрс хуулж, 50,0 мянган тн шохойн чулуу олборлоно
- Уулын ажлаар хуулах хөрсийг гадаад овоолгын талбайд тээвэрлэнэ. Хөрсний тээврийн зай дундажаар 0,6 км болно. Мөн дөрөвдөгч худаснаас үржил шимт хөрсийг хуулан зурагт үзүүлсний дагуу овоолно.

- Шохойн чулууг агуулахын талбай хүртэл 0,6 км зайнд тээвэрлэнэ.
- Уурхайн гадаад вээврийн зам шийрийн хөндийн шохойн чулууны ил уурхайгаас олборлосон шохойн чулууг уурхайн дэргэдэх тоосго шатаах баюунд шатаах

Цахилгаан хангамж:

- Шийрийн хөндийн шохойн чулууны орд нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших бөгөөд Хонгор сумын төвөөс өндөр хүчдлийн цахилгаан шугамаар цахилгаан эрчим хүчээр хангагдаж байгаа.

Зам байгууламж:

- Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших “Шийрийн хөндийн шохойн чулууны орд” газар нь Дархан сумаас зүүн урагш 4,5 км, Улаанбаатар хотоос 236 км зайтай оршдог. Улсын чанартай авто болон төмөр замын 11 км орчим алслагдсан бөгөөд эдгээр замуудад сайжруулсан шороон замаар холбогдоно.

2. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

- Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл ахуйд нөлөөлж болох сөрөг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлтүүд дээр үндэслэн тэдгээрээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгахад энэхүү үнэлгээний гол зорилго чиглэгдэнэ.
- Тус үйлдвэр нь өөрийн техник, технологио үйлдвэрлэлийн хүчин чадал, эдийн засгийн боломжтойгоо уялдуулан байнга шинэчилж илүү дэвшилтэт, байгаль орчинд хал багатай технологиор экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой юм. Гэвч аливаа үйлдвэрлэл нь байгаль орчин болон ажиллагсдын эрүүл мэндэд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөөлөл үзүүлдэг билээ. Үүнд:
- Үйлдвэрлэлийн технологийн дамжлагуудын онцлогоос шалтгаалан гарах хатуу, тоос шороо, бичил орчны температур, чийгшил, гэрэлтүүлэг,
- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал, усны гэнэтийн аюул;
- Ус, цахилгаан болон түүхий эд, туслах материал зэргийн хангамжийн саатал, өөрчлөлт зэрэг үйлдвэрлэлийн болон удирдлагын үйл ажиллагаанаас үл шалтгаалах нөлөөллүүд сөрөг нөлөөлөлд хамаарна.
- “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-д аж ахуйн нэгж бүр үйлдвэрлэлийн үед гарч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг жил бүрийн төсөл (үйлдвэр-санхүүгийн) төлөвлөгөөндөө тусгаж ажиллах нь зүйтэй гэсэн зүйл заалттай. Иймээс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж байхыг зөвлөж байна.

Шохойн чулууны олборлолт, тээвэрлэлт, тэсэлгээ зэрэг төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

Үүнд:

Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг нөлөөллүүд:

□ Шохойн чулуу олборлох үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт PM10-аас жижиг хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ ихсэх

- ☐ Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх
- ☐ Тэсэлгээ, уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрмжөөс үүсэх дуу шуугиан, тоосжилт
- ☐ Бага оврын халаалтын зуух, хүнд даацын болон бусад техникээс бохирдуулагч хий үүсэх

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- ☐ Төслийн хэмжээнд ашиглаж байгаа хатуу хучилттай зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх
- ☐ Шатахуун түгээх станц, тос тосолгооны материалын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас агаарт химийн бодис ууршин тухайн орчны агаарыг бохирдуулах.

Усны чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг нөлөөлөл:

- ☐ Уурхайн олборлолтын явцад шүүрүүлэлтийн усыг шавхсанаас гүний усны түвшин буурах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- ☐ Уурхайн хотхон болон ажилчдын кемпийн бохир ус цэвэрлэх байгууламжийн эвдрэл гэмтэл, технологийн горим алдагдсанаас үүдэн гадаргын болон газрын доорх усны чанар найрлагад нөлөөлөх.
- ☐ Шатахуун түгээх станцын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин уст үеийг бохирдуулах.
- ☐ Хаягдал чулуулгийн овоолго дахь хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчиллэг урсацын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх ус бохирдох.

Хөрсний чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг нөлөөлөл:

- ☐ Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.
- ☐ Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- ☐ Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс элдэгдэл, эвдрэлд орох.
- ☐ Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан хөрс бохирдох.

- ☐ Хуурай хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- ☐ Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

Ургамлан бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг нөлөөлөл:

- ☐ Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устгах.
- ☐ Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- ☐ Салаа зам үүсгэснээс шалгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- ☐ Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.

☐ Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх **Биологийн төрөл зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг нөлөөлөл:**

- ☐ Уул уурхай түүнийг дагасан суурьшлын бүсээс тухайн бүс нутгийн амьтан дайжих, дүрвэх.
- ☐ Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- ☐ Тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус уурхайн нийт 26 жил ашиглагдах бөгөөд уурхайлалт гүн рүүгээ явах тул ашиглалтын сүүлийн жилүүдэд техникийн сэргээн хийгдэх юм. Уурхйн талбайд тохирсон нөхөн сэргээлтийг хийх ба талбайд хайлаас болон олон настын үр тарисан. Жил болгон нөхөн сэргээх боломжтой талбайг стандартын дагуу нөхөн сэргээж байна. Үүнд:

Хүснэгт 1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Баримтлах эрхзүйн баримт бичиг	Хэрэгжүүлэх хугацаа
1	Техникийн нөхөн сэргээлт /үржил шимтэй хөрсөөр хучих/	га	2-4	1000.0	4000.0	БОНБҮТ Хууль	I-IV улиралд
2	Биологийн нөхөн сэргээлт/600ш хайлаасын тарьц/	га	1-3	5.0	3000.0		
3	Татан буулгах хаалтанд бэлтгэх	га	2	1000.0	1900.0		
4	Нийт				8900.0		

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Иннова Ложистик” ХХК-ний уурхайн орчинд биологийн олон янз байдлын судалгаа, шинжилгээ хийх, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоох зөвлөх үйлчилгээний тайлан үндэслэн зардлын хэмжээг төсөвлөж гүйцэтгэсэн болно. Дархан-Уул аймаг болон Хонгор сумын захиргаа болон холбогдох мэргэжлийн байгууллага дүйцүүлэн хамгаалах ажлын чиглэлийг жил бүр гаргаж өгч байхаар тохиролцсон. Иймд төсөл хэрэгжүүлэгч Дархан-Уул аймгийн БОАЖГ-т дүйцүүлэн хамгаалах ажлыг хийх хүсэлтэй тавьж дүйцүүлэн хамгаалах ажлыг хийсэн байгаа.

Хүснэгт 2 Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт

№	Дүйцүүлэх хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ, ш	Нэгжийн зардал мян/төг/	Нийт зардал мян/төг	Баримтлах эрхзүйн баримт бичиг	Хэрэгжүүлэх хугацаа
1	Ан амьтанд хужир марай өгөх	Сумын тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцож дэмжих	15 гаруй	200.0	3000.0	БОНБУТ Хууль	2-4-р улиралд зохион байгуулсан
	Нийт				3000.0		

5. ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлыг бууруулах үр дүнтэй арга техникийг ашиглах замаар хог хаягдлыг ангилан ялгаж хаях, хэмжээг бууруулах нь чухал юм. Хог хаягдлыг ангилан хаях, устгах чиглэлээр нийт ажилчдыг сургалтаар хангасан байна..

Хог хаягдлын талаарх сургалт

Хүснэгт 3 Сургалтын төлөвлөгөө ...

№	Нэр	Хамрагдах хүрээ	Хичээл ийн цаг	Хичээл заах багшийн нэр
1	Хог хаягдалтай холбоотой зөрчлын тухай хуулиас	Ний ажилчид	1 1 1	Байгаль орчны ажилтан
3	Энгийн хог хаягдал ба аюултай хог хаягдлын тухай ойлголт	Нийт ажилчид		
4	Хог хаягдлыг багасгах алхам	Нийт ажилчид		
		Нийт	3	

Зураг 2 Хог хаягдлын Сургалт


Хог хаягдал байгаль орчинд үзүүлэх нөлөө

✓ Ил задгай хаясан хог хаягдал нь ялзарч муудах, шатах зэргээс шалтгаалан нян бактери үржих, хорт хий ялгарах, үнс, тоосжилт үүсэх гэх мэт хүрээлэн буй орчны хөрс, ус, агаарыг бохирдуулах



✓ Хоол хүнсний хаягдал нь задарч, микро организм өсөж үржих таатай орчныг бүрдүүлэн, халдвар тархах голомт болохоос гадна тэнд цугларсан шавьж, мэрэгч нь халдвар тараагч болно

✓ Хог хаягдлаас үүсэх хүлэмжийн хий нь дэлхийн дулааралд нөлөөлөх бөгөөд озоны цоорлыг нэмэгдүүлэх




Хог хаягдлаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

➢ Зохицуулалтгүй хаясан хог хаягдал нь хөрс, гадаргын болон гүний ус, агаарыг бохирдуулан халдварт өвчин тархах (амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин)



➢ Хоол хүнсний хог хаягдал нь задарч, нян бактери өсөж халдвар тараах, шавьж мэрэгч үржиж халдварт өвчин тархах

➢ Аюултай хог хаягдлыг бусад хог хаягдалтай хамт хаяснаас түүнд агуулагдах химийн бодис нөлөөгөөр олон төрлийн өвчин үүсэх



➢ Хуванцар сав, гялгар уутны шаталтаар үүсэх хорт бодис, органик бохирдуулагч нь хорт хавдар, дээд мэдрэл, дотоод шүүрэл, дархлаа, нөхөн үржихүйд нөлөөлөхөөс гадна хүний биед биохүимтлэл үүсгэх

Зураг 3 Хог хаягдлын Сургалт

Зарим бүтээгдэхүүн, материалын байгальд шингэж алга болох хугацаа

Шил  4000 жил	Хуванцар аяга  1000 жил	Хуванцар карт  1000 жил	Нэг удаагийн аяга тавар  500 жил	Хуванцар сав  400 жил
Лааз  10 жил	Хөнгөн цагаан сав  100 жил	Асаагуур  100 жил	Тамхины иш  2 жил	Цаас  3 сар

Зураг 4 Хог хаягдлын Сургалт



6. НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах үндэслэл болдог.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартуудын дагуу төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх болзошгүй болон голлох сөрөг нөлөөллийг бууруулахын тулд авах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгө зардлуудыг тооцон гаргасан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг компанийн удирдлага тухайн жилийн үйл ажиллагааныхаа зардалд тусган төлөвлөж зарцуулж байх нь зүйтэй. Бидний боловсруулсан байгаль хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах боломж бүрдэхээс гадна төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлж, эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.

- Үйлдвэрийн ажилчдын ажиллах нөхцөл байдлыг хангах, байнга хяналт шалгалт хийх. Хог хаягдлыг удаан хугацаагаар хадгалахгүй байх, гэрээний дагуу хугацаанд нь зайлуулах
- Газрын хэвлий болон байгаль хамгаалах, ашигт малтмалын тухай хуулиудын холбогдох заалтуудыг эрэл хайгуулах болон ашиглалтын явцад чандлан мөрдөх
- Эрэл хайгуулын суваг, цооног, шруп малтмал зэргийг гүйцэтгэсний дараа ашиглахгүй үлдсэн хэсгийг эргүүлэн булж тэгшлэн нөхөн сэргээлт хийх
- Олборлолтын явцад болон олборлолтын дараа тус талбайд үүссэн нүх, карьер хүн ард, мал амьтан унахааргүй байхаар ахмгаалах бүрэн хэмжээнд нөхөн сэргээх шаардлагатай
- Агаарын бохирдол болон бусад үзүүлэлтүүдийн шинжилгээг жилд 1 удаа байнга авч шинжлүүлэх. Ялангуяа тоос, дуу чимээ гэх мэт үзүүлэлтүүдийг нарийн тодорхойлуулах. Тос тослох материалыг хөрсөнд нэвчихээр ил задгай хаяхгүй байх. Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, тогтмол хяналт шалгалт хийх.
- Ургамалжуулах зүлэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөгөөг авч ажиллах.
- Үйлдвэрийн хаягдлыг байгаль орчинд халгүй болгон зайлуулах.
- Ахуйн хог хаягдлын цэгийг 3х4м-ийн харьцаатай бетонон суурьтай 3 ангилалтай байхаар байгуулах
- Хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын сав баглаа боодлоор боож, төрөлжүүлэн зайлуулах
- Агаарт үүсэх тоосны бохирдол болон дуу чимээний бохирдлыг багасгах, арилгах талаар арга хэмжээ авч, багасч буй тал дээр анхаарч байнга судалгаа хийх.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг жил бүр гүйцэтгэж, тухай бүр нь батлуулан хэрэгжүүлж ажиллах.
- Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар тус тайлангийн бүлгүүдэд тусгасан заалт зөвлөмжүүдийг биелүүлж ажиллах арга хэмжээг авах
- Хонгор сумын нутаг дэвсгэр болох өөрийн Уурхайн бүс орчим дотор 2000 ширхэг хайлаас болон бургас мод тарьсан.

Зураг 5 Модны суулгац тарих бэлтгэл ажил болон тарилт



Зураг 6 Модны суулгац тарих бэлтгэл ажил болон тарилт



7. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Компани нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх ажилласан.

1. Агаарын бохирдол

- Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлт: Ажлын байрны агаар дахь тоосжилт болон бусад үзүүлэлтүүд
- Хяналт шинжилгээний төрөл, хэлбэр: Сорьц авч шинжилгээ хийх
- Байршил: төслийн талбай орчмын цэгүүдээс

2. Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол

- Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлт-Хөрсний геохимийн үзүүлэлт, бохирдолт
- Хяналт шинжилгээний төрөл, хэлбэр

Ашиглалтын хугацаанд хөрсний геохимийн үзүүлэлтийг шинжлүүлсэн байна.

Зураг 7 Шинжилгээний дараалал

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараалал



Зураг 8 Уурхайн дэргэдээс агаарын хэмжилт хийж байгаа байдал.



Зураг 9 Үйлдвэрийн орчинд Хөрсний хэмжилт хийж буй хэсэг.



**8.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН БИЕЛЭЛТ**

Хүснэгт 4

№	Хэрэгжүүлэх ажил	Зардал мян, төг	БИЕЛЭЛТ
1. Хөрсний эвдрэл, бохирдол, хог хаягдлыг багасгах			
1.1	Уурхайн бүсийн дотор хайлаас болон агч мод тарьж ургуулсан	2500.0	1500 ШИРХЭГ МОД БУТ ТАРЬСАН
1.2	НААҮГ-тай гэрээ байгуулан үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг тогтмол ачуулж, орчноо байнга цэвэр байлгах / сургалт авсан/	200.0	1 ЖИЛД 15 УДАА ХОГ ХАЯГДАЛ АЧУУЛСАН
1.4	Уурхай орчмын ба дотоодын тээврийн замыг сайжруулан засах, тэмдэгжүүлэх ухуулах самбар байрлуулах	300.0	ТЭМДЭГЖҮҮЛСЭН
1.6	Уурхайн малталтын дүүргэлт ба налуулж тэгшлэх	700.0	ДҮҮРГЭЛТ ХИЙСЭН
3.Дүйцүүлэн хамгаалах зардалд			
4.1	Үйл ажиллагаа явуулж байгаа чиглэлтэй холбоотой хууль дүрэм журамыг танилцуулах ажиллагааг нийт ажилчдын дунд зохион байгуулах	500.0	ТӨЛӨВЛӨСӨН ЁСООР 90% ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН БОЛНО
4.3	Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө	9650.0	
4.6	Дүйцүүлэн хамгаалаллын зардалд	3000,0	АН АМЬНЫГ ХУЖИР МАРАЙ ӨГӨХ АЖИЛД ОРОЛЦСОН
	<u>Нийт зардал</u>	<u>16800.0</u>	

9.БОМТ-ИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд боловсруулагдсан энэхүү тайланд төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийн хүрээнд нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнасан байна.

Хүснэгт 5 Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах тайлан

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнах	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал	Зохион байгуулах газар	Хариуцсан ажилтан
1	Хонгор сумын оршин суугчид	семинар	БОХТ-ий нөлөөллийг тайлбарлах	2-4-р улиралд	500.0	Компаний байранд	БО-ы ажилтан
	Нийт				500.0		

Зураг 10 БОМТайланг тайлагнаж байгаа байдал



2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХЭД

Манай компани 2024 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр төлөвлөсөн ажлуудаа “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” болон холбогдох дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэсэн. Компаний байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсаны дагуу үйлдвэрлэлийн ажил явагдаж байгаа хэсгүүдэд хийгдсэн байгаль орчныг хамгаалах ажил болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийг дараах байдлаар дүгнэж байна.

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийг нэмэх болон тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд манай компани нь 2000 гаруй ширхэг бургас болон хайлаас модыг тарьсан.
- Байгаль орчны менежментийн хүрээнд хяналтын цэгүүдийг тогтоож хагас жилд нэг удаа дээжлэлт хийж байх тогтсон цэгүүдтэй болсон. Үүнд: Агаар, хөрсний шинжилгээг Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн лабораториор хийсэн болно. Шинжилгээний үзүүлэлтүүд стандарт хэмжээнээс давсан тохиолдолгүй байна.
- 2024 онд орон нутгийн татварт ус, газар, хог хаягдлын төлбөрийг хугацаанд нь төлсөн байна.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоох зөвлөх үйлчилгээний тайлан үндэслэн зардлын хэмжээг төсөвлөж гүйцэтгэсэн болно Үүнд: Ан амьтны идэш тэжээлд зориулсан жужир марай тавьж өгсөн.
- Орон нутгийн иргэд болон холбогдох байгууллагат заагдсан хугацаанд тайлангаа тайлагнасан болно

Цаашид Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тусгагдсаны дагуу жил бүр тайлан төлөвлөгөөг бүтэн хугацаанд нь хийж гүйцэтгээд түүнийгээ тайлагнаж, дүгнүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

Зургийн жагсаалт

Зураг 1. Технологийн схем

Зураг 2 Хог хаягдлын Сургалт

Зураг 3 Хог хаягдлын Сургалт

Зураг 4 Хог хаягдлын Сургалт

Зураг 5 Модны суулгац тарих бэлтгэл ажил болон тарилт

Зураг 6 Модны суулгац тарих бэлтгэл ажил болон тарилт

Зураг 7 Шинжилгээний дараалал

Зураг 8 Уурхайн дэргэдээс агаарын хэмжилт хийж байгаа байдал.

Зураг 9 Уурхайн дэргэдээс агаарын хэмжилт хийж байгаа байдал.

Зураг 10 БОМТайланг тайлагнаж байгаа байдал

Хүснэгт 1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2 Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 3 Сургалтын төлөвлөгөө

Хүснэгт 4 төсвийн тайлан

Хүснэгт 5 Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах тайлан



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар **MV-016833**

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

_____ **Дархан-Уул** _____ аймаг /хот/-ийн
_____ **Хонгор** _____ сум /дүүрэг/-ын
_____ **Шийрийн хөндийн адаг 4-р орд** _____ нэртэй газарт орших
_____ **24.88** _____ гектар талбай бүхий уурхайн талбайд
хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг
зөвшөөрч улсын бүртгэлийн **9011416076** _____ тоот гэрчилгээтэй
_____ **“Инноваложистик” ХХК** _____ -д
энэхүү тусгай зөвшөөрлийг **2033.04.21** _____ дуустал
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА _____ **Д.МӨНХТАМИР**



2003 оны 4 сарын 21 өдөр
Улаанбаатар хот


0000135



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**

MV-016833

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
024-FE	Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 20 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.04.21 – 2023.04.21 хүртэл	
025-FE	Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 21 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.04.21 – 2024.04.21 хүртэл	

БАТЛАВ:
“ИННОВА ЛОЖИСТИК” ХХК-ийн
ЗАХИРАЛСАН
Co. 110

ТАНИЛЦСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б. МӨНХТӨР

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ШИЙРИЙН ХӨНДИЙН АДАГ 4-Р” ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ / тодотгол/**

(Жилийн хүчин чалал 100.0 мян.тн шохойн чулуу)
(Тусгай зөвшөөрлийн дугаар MV – 016833)

ХЯНАСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Э. БОЛД-ЭРДЭНЭ

ШИНЖЭЭЧ:
МУ-ЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР
Г. УРАНБАЙГАЛЬ

ЗӨВЛӨСӨН:
МУ-ЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР
Ж. МӨНХДЭЛГЭР

БӨЛӨВСРҮҮЛСАН:
УУЛ УУРХАЙН ЗУРАГ ТӨСЛИЙН “ЭМ БИ ЭКСПЕРТ” ХХК-ийн
ЗАХИРАЛ:
П. АРИУНГЭРЭЛ

ЗОХИОГЧИД:
УУЛ УУРХАЙН МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР
УУЛЫН ИНЖЕНЕР
УУЛЫН ИНЖЕНЕР
ЭДИЙН ЗАСАГЧ
Б. МӨНХБАТ
Д. БАТ-ОЧИР
А. АРИУНБОЛД
Н. ГАНЗОРИГ